



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХАНХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 20 өдөр

Дугаар А/С/4

Ханх сум

Газар хөдлөлтийн үед иргэдийг нүүлгэн шилжүүлэх түр байр, түр цугларах талбай, нисдэг тэрэг буух зогсоолыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар хөдлөлтийн үед нүүлгэн шилжүүлэх түр байрыг Дотуур байр, Спорт заал, түр цугларах талбайг Засаг даргын Тамгын газрын урд талбай, Ерөнхий боловсролын сургуулийн спорт талбай, нисдэг тэрэг буух зогсоолыг сумын төвөөс зүүн зүгт Ханхын талд 7 км зайд болгосугай.

2. Дээрх объектуудыг гамшгийн үед бүрэн хэмжээгээр ашиглахад бэлэн байдлыг хангаж ажиллуулахыг хариуцах эзэнд даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч бөгөөд Байгаль орчин, тогтвортой хөгжлийн бодлогын тасгийн дарга (Б.Баттүвшинд)-д даалгасугай.

ДАРГА



Л. ДАВААБАЯР

МОНГОЛ
ХӨВСГӨЛ АЙМГ

Боловсрол
Хүнс
Хүнс

My doc-2024 Zahiramj

070710167